



Бэсрэг уртын дуу

Дээд, доод өнгө нь өргөн биш цар хүрээтэй, шуранхайгүй, хэм тодорхой, хэмнэл тодорхой, уртын дууны хувьд аялгууны хувьд багавтар дууг **бэсрэг уртын дуу** гэнэ.

Жишээ нь: “Дөрвөн настай халиун”, “Шалзат баахан шарга”, “Хүрэн толгойн сүүдэр”, “Тоорой Банди” гэх мэт...



Суман уртын дуу



Цар хүрээ нэлээн өргөн, уран гоё
нугалаа, хугалаа, чимэглэл
цохилоготой, давхар биш
шуранхайтай, уужим тавиун аялгуу
бүхий дууг **суман уртын дуу** гэнэ.

Жнь: “Эрдэнэ засгийн унага”,
“Зээргэнтийн шил”, “Эр бор харцага”
гэх мэт...



Айзам уртын дуу



Уужим тавиун тэнэгэр аялгуутай, өргөн цар хүрээтэй, төв эрхэмсэг намба төрхтэй, уран гоё нугалаа, чимэглэл, цохилготой, дан болон давхар шуранхайтай, октав давсан хол үсрэлттэй, зохиомжийн чөлөөт хэлбэртэй дууг айзам уртын дуу гэнэ.

Бэсрэг уртын дуу “Дөрвөн настай халиун”





Удаан

Дөр - вөн _____ нас - тай _____ ха - лиун _____ 3 нь
Дөр-вөлж-лөөд _____ ха-раг - дах _____ ба - раа _____ нь

The first system of the musical score for 'Удаан' is in 4/4 time. The vocal line (treble clef) features a melody with a dotted half note, a quarter note, and a triplet of eighth notes. The piano accompaniment (bass clef) consists of a steady eighth-note pattern. The lyrics are written in Mongolian and Russian, with horizontal lines indicating the placement of the notes.

4
Дө - рөө _____ жий - хэд _____ ер _____ гөө _____ - тэй шүү
Дө-төл-сөн _____ ам - ра - гийн _____ ба - раа _____ юу

The second system of the musical score for 'Удаан' continues the melody. It features a triplet of eighth notes and a dotted half note. The piano accompaniment remains a steady eighth-note pattern. The lyrics are written in Mongolian and Russian, with horizontal lines indicating the placement of the notes.



**Монгол ардын уртын дуу
сэтгэлгээний хувьд:**



**Гүн гүнзгий утга
агуулгатай**



**Ухаарал бодрол
шингэсэн**

ЕРГҮҮЛЭХ, ДЭРГҮҮЛЭХ-, Доргио
явдал
ДӨТӨЛСӨН АМРАГ- хайртай амраг
ТАВААР ТАВЬСАН ГЭЗЭГ...
ТАВАЛЖААД ХАРАГДАХ ...
ТААНЫН БУТУУЛ...



Ноотны дэвтэр дээрээ бичээрэй.

ДӨРВӨН НАСТАЙ ХАЛИУН (Монгол ардын бэсрэг уртын дуу)

Удаан

Дөр - вөн _____ нас - тай _____ ха - лиун _____ 3 нь
Дөр-вөлж-лөөд _____ ха-раг - дах _____ ба - раа _____ нь

Дө - рөө _____ жий - хэд _____ ер _____ гөө _____ - тэй шүү
Дө-төл-сөн _____ ам - ра - гийн _____ ба - раа _____ юу

Эхний 3 айзмын ноотыг **ФА** түлхүүрт хөрвүүлээрэй.



Дүгнэлт

Монгол уртын дуу бол монгол ардын дууны **сонгодог хэлбэр** мөн бөгөөд **дэлхий дахинд** ардын дууны шинж төлөвтэй харьцуулан үзэхэд нэн өвөрмөц, гайхам сонин, чухам **Монголын урлал** гэж үздэг. Уртын дуу бол уудам тэнэгэр сайхан **нугалаатай**, уянга төгөлдөр олон янзын **гоёмсог эгшиг чимэгтэй**, хүний сэтгэлийг хөдөлгөн догдлуулам хөгжүүн **бадрангуй сайхан аялгуу** нь оргилон дээшилж, нарийсан нарийссаар **"шуранхайлах"**, тэгснээ доошилж нугалаа хугалаа, хоолой амьсгалын цохилт хийж, хүнгэнэн **өргөн цараатай**, сонсож ханашгүй **эгшиглэнтэй**гээр хадаадаг нь Монгол сайхан эх орны тэнэгэр **уудам тал нутаг** хийгээд, дэлгэр баян хангайн **сүрлэг өндөр уул нуруу**, даваа гүвээ, өргөн тунгалаг **гол мөрөн**, өтгөн хөвч **ой шугуй**, үзэсгэлэн төгс байгалийн тансаг сайхан бүхнийг санагдуулж, **агт морьдын** хурдан жороо ажнай сайныг бодогдуулж, **унасан газар**, угаасан ус, **эцэг эх** элгэн садан, **үр хүүхдүүд**, үнэнч журмын амраг **хань**, **анд нөхдөө** хайрлах **эх оронч сэтгэл**ийг маань ундруулам сайхан билээ.

Гэрийн даалгавар

Дүгнэлт хэсгийн улаанаар бичсэн үгүүдийг оролцуулан уртын дууны тухай зураглал хийж явуулаарай.